

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

АУДИТЫН ДҮГНЭЛТ

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн (цаашид “компани” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн **“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн** санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулийн эдгээр шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах, залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийг тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Аудиторын зорилго нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад оршино. Ул үндэслэлтэй баталгаа нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь материаллаг болж, эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэл болж болзошгүй гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

Санхүүгийн тайлангийн аудитын үед аудиторын хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ММНБИ-ын monisra.mn сайтад байрлах манай аудитын компанийн холбоосонд байрлуулсан бөгөөд энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл нь бидний аудиторын тайлангийн хэсэг болно.



Баталсан: "Мэдээлэл Аудит" ХК

Гүйцэтгэх захирал

Д.Товуудорж

2020-03-23